

“ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС”-ЫГ ЗАДАЛЖ ҮЗЭХҮЙД

Н.Ариунзаяа*

* «Отгонтэнгэр» их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үг: мөн чанар, сэрэл сэтгэмж, цаг үе, цадиг түүх, хүй нэгдэл, омог, наймаачин, бодит орлого, хэм хэмжээ, эрх зүй, баяр, хүмүүжил, соёл иргэншил

Монгол оронд олон нийтэд мэдээлэл түгээх зориудын хэрэгсэл болох сонин гарч, үндэсний сэтгүүл зүйн эхлэлийг тавьсан цагаас хойш нэгэн зууныг ардаа орхиж, хоёр дахь зуун жилийн босгоор алхан орлоо. Зуун жил гэдэг дэлхийн сэтгүүл зүйн түүхтэй харьцуулбал богинохон хугацаа боловч, хөгжиж дэвжих, сурч мэдэх, арга туршлага хуримтлуулахад хангалттай хугацаа билээ. Тэр тусмаа дэлхийн сэтгүүл зүйн хөгжлийг дагаж биш, амдаж хөгжсөн нь Монголын сэтгүүл зүйн нэг онцлог юм.

Монголын сэтгүүл зүй эдүгээгээс зуун нэгэн жилийн тэртээ Орос, Манж, Хятад зэрэг орны сонин хэвлэлд ажиллаж, тогтмол хэвлэл гэгчийг мэдэх болсон хүмүүсийн гар, ухаан хоёроор эх сууриа тавьсан бол, хориод оны хувьсгалт хэвлэл тухайн үедээ тэргүүний гэгдэж байсан Оросын сэтгүүл зүйн дэг сургуулийг өөриймшүүлэн хөгжсөн юм. XX зуунд гарсан Монголын гурван их хувьсгалын сүүлчийнх нь болох 1990 оны ардчилсан хувьсгалын

дараа ч Америк мэт чөлөөт сэтгүүл зүй өндөр хөгжсөн орнуудын туршлагыг үндэсний бичиг соёлын уламжлалтайгаа хослуулан авч хэрэглэсэн билээ.

Энэ хугацаанд Монголын сэтгүүл зүйн арга туршлага хөгжингүй сэтгүүл зүйн түвшинд хүртэл хуримтлагдаж, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн цогц систем тогтож, сэтгүүл зүйн туурвилын төрөл, зүйл төлөвшин бүрэлдэж, үндэсний сэтгүүлч боловсон хүчний хэд хэдэн үеийг сургаж хүмүүжүүлсэн нь бодтой ололт юм. Түүний зэрэгцээгээр Монголын ард түмнийг нэгэн зууны турш мэдээллээр хангаж, гэгээрүүлж, соёлжуулсан нь түүнээс ч илүү ач холбогдолтой оюун санааны үр дүн мөн билээ.

Нэгэн улс үндэстний хувьд зуун жил гэдэг ихийг үзэж өнгөрөөх, элдвийг туулж гарах хугацаа юм. Тэр ч учраар Монголын сэтгүүл зүй өнөөдрийг хүртэл арга барил, ур чадвар, бүтээл туурвилын арвин туршлагыг хуримтлуулсныг түүх шастирт бүрэн үлдээ гэвэл хэдэн арван хасаг тэрэг ном болох биз ээ. Тийм түм буман санаа сэдэл, арга барилын нэгийг сэтгүүлч Үржингийн Хүрэлбаатарын нэртэй холбож үзэхээс өөр аргагүй байна. Манай сэтгүүл зүйн түүхэнд шинэ хэвлэл мэндлэх юм уу, эсвэл аль нэг сонин, сэтгүүл цаг үеийн чухал

асуудалд зориулж "Редакцийн зурвас" нийтэлдэг туршлага эрт үеэс уламжилж ирсэн юм. Тэр нь "Сонордуулга", "Сонсгох нь", "Эрхлэгчийн зурвас", "Редакцийн зурвас" гэх мэт нэрийн дор гардаг байсан, одоо ч гарсаар байгаа. Харин тийм зурвасыг янз бүрийн сэдвээр бүтэн жилийн турш дугаар алгасалгүй нийтэлж байсан удаа үгүй билээ. Ийм санааг Ү. Хүрэлбаатар бодож олсон нь тогтмол хэвлэлийн түүхэнд гарсан анхны тохиолдол болжээ.

Сонин санааг бодож олох нэг хэрэг. Харин түүнийгээ хэрэгжүүлнэ гэдэг өөр асуудал. Тэр тусмаа өдөр тутмын сонинд бараг өглөө бүхэн нэг юм бичнэ гэдэг " аль ч хэрэг арван таванд" гэдэг шиг, юм бүхэнд оролцож, зохицуулж явдаг эрхлэгчийн хувьд санаснаар бүтчих хэрэг биш билээ. Гэвч үүнийг Ү. Хүрэлбаатар хийж чадсан юм. Чиглэсэн зорилготой, хувийн эмх цэгц, дэглэм сайтай хүний хийдэг ажил, бичиж туурвих үйлс гарт нь орсон, уйгагүй, тэвчээртэй уран бүтээлчийн давж гардаг даваа юм. Тиймээс ч тухайн үед хотын дарга байсан Ж. Наранцацралт агсан "Энэ нь нэг талаас тухайн өдөрт тохиож буй үйл явдал, үзэгдэл юмсын мөн чанарыг товчоолон бичсэн он цагийн лавлахын таталбар мэт, нөгөө талаас сэтгүүлчийн хувьд окуунаа дасгалжуулж, байнгын урагш тэмүүлэх эрч хүч, эрж хайж буй талбар мэт санагддаг байв. Үнэхээр өдөр тутмын сонин бүх дугаарт алсгал үгүй бичнэ гэдэг бэрх бөгөөд, энэ нь ерөнхий эрхлэгчийн их ажлын зөвхөн нэгээхэн хэсэг аж" хэмээн өндөр үнэлсэн байдаг.

Ү. Хүрэлбаатар эрхлэгчийн "зурвас"-ын сэдэв өргөн, санаа гүн, үг хэл цэгцтэй, уншиж үзэхэд наалдацтай юм. "Зурвасын сэдэв нь цаг үе, үйл явдал, агуулга нь хүний нийгмийн харилцан

шүтэлцээ, хэлбэр нь богинохон зай талбай юм. Ийм бага зайд тийм агуулгыг багтаана гэдэг сэтгүүлчийн ур чадвар, сэрэл сэтгэмжийн өвөрмөц байдал билээ" гэсэнтэй ч санал нийлэхгүй байхын аргагүй юм. Үнэхээр ч "Ерөнхий эрхлэгчийн зурвас" юм бүхний тухай өгүүлж байна. Төрөл зүйлийн хувьд өгүүлэл, тэмдэглэл, уран нийтлэл, зарим газарт төрөгдөл ч гэмээр бичлэг тааралдаж байгаа бол, сэдвийн хувьд ангилж төрөлжүүлэхэд нэн бэрх юм. Тийм байхаас ч өөр аргагүй аж. Нэгэн жилд нийгэм болоод нэг хүний амьдралд юу эс тохиолдох билээ. Тэр тусмаа нийгэм олны төлөө сэтгэл чилээж, санаа тавьж явдаг уран бүтээлчийн ахуй, сэтгэлийн орон зай их багтаамжтай байх нь аргагүй билээ. Дээр нь "Улаанбаатар хот" гэдэг их айлын харах нүд, сонсох чих болсон сонинных нь эрхлэгчийн анхааралд өртөх асуудал илүү өргөн хүрээтэй байх нь мэдээж.

"Ерөнхий эрхлэгчийн зурвас"-ыг тасралтгүй нийтэлж, нэгэн цогц бүтээл- ном болгосон нь хэлбэр донжийн хувьд шинэлэг, анхдагч болохын зэрэгцээ, агуулгын хувьд бүр ч сонин юм. "Бүтээл, түүний хэл найруулга бол хүн өөрөө юм" гэж нэгэн их ухаантан хэлсэн байдаг. Зурвасуудаас Ү. Хүрэлбаатарын дотор сэтгэл рүү өнгийж харах боломжтойн дээр түүний бүтээлч үйл ажиллагааны онцлогийг илэрхийлэх хэд хэдэн үнэт чанарыг тодруулж болохоор байна.

Юуны өмнө Ү. Хүрэлбаатар ясны сэтгүүлч юм. Нэгэн жилд нэгэн улс орны зурх тархи болсон нийслэл хот, түүний бужигнасан амьдрал дундаас өдөр бүр хамгийн чухал, бас содон соргог ганцхан үйл явдлыг сонгож олно гэдэг сэтгүүлчийн улс төрийн өргөн хараа,

уран бүтээлчийн авьяас мэдрэмж шаардах хэрэг билээ. Өөр үгээр хэлбэл сэдвийн ач холбогдлыг үнэлэх чадвар хэрэгтэй. Энэ талаар Ү. Хүрэлбаатар өөгүй хүн юм. Сэдэв гэдэг нь үнэн чанартаа цаг үеийн тусгал байдаг. Зохиогч ч энэ үүднээс хандаж өдөр бүрийн сэдвийг бодож олсон гэлтэй. "Ерөнхий эрхлэгчийн зурвас" 1997 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхэлсэн байх бөгөөд энэ өдрийн зурвасыг "Нэгдүгээр сарын нэгэн" гэж гарчиглажээ. Ерөн- цийн нэгэн шинэ жил эхэлж байхад өөр юуны тухай бичих юм бэ? Тэрхүү ирж байгаа онд юу хийж бүтээхээ бичихгүй бол өөр юуны тухай бичих юм бэ? Тэгээд ч зохиогч "Ертөнц хэдий баян ч нэгэн ширхэгээс л эхтэй. Нэгдүгээр сарын нэгэн хэмээх нэгэн жилийн нээлт дотоод мөн чанараараа давтагдашгүй" гэсэн байна.

Эрхлэгч хүн оны эхэнд ажлаа, сониноо ярихгүй бол, өөр юу ярих билээ. Ү. Хүрэлбаатар эрхлэгч тэр л ёсоор зурвасаа сонин- тойгоо холбож, зорилтоо тодорхойлсон байна. "Улаанбаатар сонин 1997 онд уншигч танаа 248 дугаар өргөн барина. Дугаар тутам нийслэлийн энэхэн цаг үеийн цадиг түүхийн бичээс болж танд шинэ мэдээлэл, шинэ мэдлэг олгох болно. Нийслэлийн олон талт амьдра- лын тухай үнэн зөв, бодитой, шуурхай мэдээллийг чухамхүү манай сониноос эмх цэгцтэй олж мэдэж болохыг шинэ оны эхний өдөр батлан хэлж байна" гэж итгэл дүүрэн хэлсэн байна. Зурвас цаашаа "Үүцээ задлахуй", "Оргилуун дэрс", "Орцон дахь гөлөг" гэх мэтээр хөвөрчээ. Хэрэв "Ерөнхий эрхлэгчийн зурвас"-ыг өдөр тутмын үйл явдлын бичиглээс гэж үзвэл зарим нь цаг хугацаанд захирагдахгүй, задгай бич- лэг гэмээр санагдаж болно. Гэвч тэр нь учиртай аж. Оны эхэнд эрхлэгч өөрөө

"Энэ буланд ерөнхий эрхлэгчийн хувь бодол, бодрол ухаарал, сэрэл сэтгэмж шингэх болно" гэсэн. Тийм сэрэл сэтгэмж буюу амьдралд хандах ханд- лага, үзэл бодлоо илэрхийлсэн төрөгдөл маягийн бичлэг олон байгаагийн нэг нь "Орцон дахь гөлөг" юм. Уг бичлэг "Чих нь унжсан дөрвөн нүдтэй халтар гөлөг яахын аргагүй монгол нохойн удам аж. Хөл нь солбин, данхар толгойгоо дааж ядан баацагнах нь хорвоод мэндлээд удаагүйг илтгэх бөлгөө" гэж эхэлдэг. Тэгээд "Харуу бүрий болоход гаслан гийнаж, нохойны хүү гэсэндээ улир хуцаж өлсөж, даарч буйгаа эрхгүй зарлаж, түүнийхээ шанд залхсан суугчдын залхаалтыг амсаж, бас цэвэрлэгч авгайн шүүрний үзүүрт сав л хийвэл өртөж, улам чанга гаслан орилох халтар гөлөг ойрд чимээгүй болов. Тэр нь цэвэрлэгч авгай өөрийн эзэмшлийн газраасаа холдуулан төө- рүүлсэн хэрэг бөгөөд нэн удалгүй дахиад л хүрээд ирвэ" гэх буюу "Тэрээр орой үдэш урьдын адил орилон гангинахаа больж, харин хэн нэгний анхаарлыг аль болохоор татахгүйг хичээн дулаан булан бараадах болжээ. Өдрийн цагаар орцныхоо хүмүүсийг танимхайран, харин согтуу хөлчүү нэгэн таарвал хэрээ мэдэхгүй жөв жөв хуцан чимээлэх тул байнгын гэрт байх хөгшид баахан ханьсах маягтай болжээ. Ийнхүү халтар гөлөг орцонд төрж, орцонд өсч, орцны ноорхой буланд оромжтой болон төвхнөв" гэх мэтээр хүн, нохой нь холилдсон нийслэлийн амьдралын нэгэн таагүй дүр зургийг нүдэнд үзэгдтэл дүрслэн бичсэн байна. Тэр гөлгийг нэгэн баян айлын залуу тайган нохойгоороо бариулж бахаа хангасан тухай өгүүл-сэн хэсэг гүн агуулгатай ажээ. Яг л тэр гөлөг шиг ааг омогтой хэний ч гарын шүүс болоход бэлэн, өмгөөлж

хамгаалах хэн ч үгүй "эмзэг бүлгийн" гэсэн хаягтай хүүхдүүд санаанд ороод ирнэ. Бас гадны юмыг хэт шүтээд, үндэснийхээ уламжлал, зан заншил, эд өлгийг мартаж байгааг ч далимд нь түншээд авсан байх жишээтэй. Маш богинохон зайд асар олон санааг хэлж, үзэл бодлоо илэрхийлсэн ийм бичлэг олон байна. Тэдний жишээнд "Эзэнгүй эс оршихуй", "Улаанбаатарын цагаан шөнө", "Реквиём" зэргийг дурдаж болно.

Ү. Хүрэлбаатар "Эзэнгүй эс оршихуй" гэдэг төрөгдөлдөө "Ер эзэнгүй юм хэмээгч буй орчлонд бий юү?" гэж өөрөөсөө асуугаад "Үгүй" гэж шуудхан хариулжээ. "Гэтэл эзэнгүй хөрөнгө, эд хогшил, тэр байтугай эзэнгүй хүүхдийн тухай нийгэм догитол юуны учир ярина вэ. Эрэгнээс төрж, элснээс тасарсан хүн гэж үгүй байлтай. Хот нийтийн эзэмшлийн юм бүхэн

эзэнгүй гэлцэх юм. Тэр чинь төрийн юм, тэр тусмаа миний юм. Ийм сэтгэлгээ хаашаа халин одов" гэж ноцтой эргэцүүлжээ. Тэгээд "Байдлыг эргэцүүлбэл нээрэн эзэнгүй орчлонг хүмүүн эзэгнэхийн төлөө амьдран буй мэт. Тэрхүү хүмүүний өмчийн түрэмгийлэл хуурай газрыг хуу хамаад тэнгис далай, сансар огторгуйд санаархаж байгаа нь илэрхий. Гэтэл газар шороо, уул ус, ургамал амьтан, тэнгис далай, тэнгэр тэргүүтэн цөм эзэнтэй агаад тэр нь буй орчлонгийн оршин тогтнохуйн өөрийн нь зүй тогтол билээ. Ийн үзвэл орчлон өөрөө өөрийнхөө эзэн нь аж. Тиймээс энэ орчлонд эзэнгүй юм гэж үгүй. Харин хүний үйл

ажиллагаанаас байгаль эхийн оршин тогтнохуйн зүй тогтол алдагдвал эзэнгүй оршихуй энэ орчлонг нөмөрнө" хэмээн өөрийн үзлээ илэхийлсэн нь яах аргагүй төрөгдлийн элемент байна.

Ү. Хүрэлбаатар цаг үеийн ажил, нийгмийн амьдралын тулгамдсан асуудал, тухайлбал ажил хэргийн тухай бичсэн зүйлдээ ч, уран бүтээлчийн торгон мэдрэмж, ертөнцийг үзэх үзлээ товч бөгөөд эвлэгхэн хавчуулж чаддаг өвөрмөц барилтай хүн юм. Ийм бүтээ-



У.Хүрэлбаатар цаг үеийн ажил, нийгмийн амьдралын тулгамдсан асуудал, тухайлбал ажил хэргийн тухай бичсэн зүйлдээ ч, уран бүтээлчийн торгон мэдрэмж, ертөнцийг үзэх үзлээ товч бөгөөд эвлэгхэн хавчуулж чаддаг өвөрмөц барилтай хүн юм



эхэлсэн энэ нийтлэлд зохиогч "Өдөр шөнө солигдох, сайн муу эргэцэх төдийгүй амь амьдрал тэргүүтэн алаг орчлонгийн тавилан заяаны битүү тойрог мэт санагдана. Тэр тойрог аугаа их орон зай бөгөөд, түүнд наран төвтэй гариг эрхсийн хөдөлгөөнөөс алив амьд амьтны нэгэн удаагийн амьсгалын эгшин хүртлэх цаглахуйн цагийн хэмжээс цөм багтана. Ийн бодоход гэрэл гэгээ, сүг сүүдэр хоёр биеэ хөөн ангуучилж, басхүү нэг нь нөгөөгүйгээр үл оршин тогтох аж" хэмээн гүн ухааны шинжтэй эргэцүүлээ хавчуулаад авсан байх жишээтэй.

Ү. Хүрэлбаатар заримдаа юмыг гайхалтай хийсвэрлэн сэтгэж, сонгодог

зохиолын хэв загвараар дүрсэлдэг онцлогтой байна. Ийм бүтээлийн нэг нь "Реквиём" хэмээх бичил нийтлэл юм. Австрийн хөгжмийн их зохиолч В. А. Моцартын "Реквиём" гэдэг алдарт зохиол хэрхэн бүтсэн тухай өгүүлсэн энэ нийтлэл ур зохиомж, дүр дүрслэлийн хувьд нэн сонин, бас содон болжээ. Нийтлэл "Тас харанхуй шөнө хар хувцастай нэгэн хаалга зөөлөн тогшиж орж ирэх нь эрлэгийн элч мэт сүүтэн аж. Ус балгасан мэт дуугүй ч, нүүрэн дэх гүн сорви нь таталдсан тэр усан нүдэт, цусан зүрхт хүмүүний эрхэмсэг дүр өрөөн доторх эд юмс, эзэн юуг нь ховх сорох мэт эзэмдэх нь аюушлигтай" хэмээн эхэлж байгааг уншихад ар нуруу руу хүйт оргиж, өргүй юм болох нь дээ гэх сэтгэгдэл төрөх аж. Зүрх түгшин цааш уншвал "Гуч хол гараагүй ч овор суусан гэрийн эзэн залуу ухасхийн босч, саяын үйл явдлыг ойлгохыг хичээн гараа элгэндээ тэвэрч, умгар тасалгаандаа холхиж" байгааг дүрсэлсэн байна.

- Реквиём, реквиём хэмээн алхам тутамдаа үглэж бухимдах тэр эрд сансарын хязгааргүй урсгал өрөөг нь дайраад өнгөрөх мэт санагдахуйяа элдэв сүг сүнс хоргодон үлдэв үү гэлтэй сэжиглэн ийш тийш харлаа. Өрөөн дэх зүйлс, хуучин төгөлдөр хуур, нотны цаас цөм буй газраа хэвээр авч нэг л өөр. Урьд өмнө таашаалт аялгуу цутган орж ирдэг байсан салхивчаар гунги гутралын гэгэлгэн дуун шүргэн шүргэн эргэлдэвч, арайхан нэвтэрч үл зүрхлэх аж. Ертөнцийн явдлаас уйдсан оюун биеэс тасарч, басхүү биед эргэн шингэх гэж эргэлдэнэ. Тас харанхуйд сүнс гэрэлтэж, манант дүрсээ үе үе тодруулах боловч уур мэт замхран одно" гэх буюу "Сансарын аугаа их орчлон өөрөө ертөнцийн төв цөм болж, галт бөмбөлөг мэт бадарсан оюуны

дээд мандлыг хэдийнэ үүсгээд тэр нь наран, сарны таталцал мэт оршин тогтнохуйн залуурыг хөдөлгөн буй санагдана. Гарт үл баригдаж, нүдэнд үл үзэгдэх тэр эрчимт хэлбэлзэл хөг ая хөлөглөж, хүчит хүрхрээ мэт шаагихад мөнөөх зовлонт хүмүүн эрхгүй босон харайж, төгөлдөр хуурынхаа хар, цагаан хосолсон товчлуурт хүрэхүй урьд өмнө сонсоо нь үгүй оволзсон, оргилсон эрчмийн далд аялгуу тунаран тунаран урсав" гэж хөгжмийн их зохиолчийн онгод хэрхэн хөглөгдөж байгааг гайхалтай хийсвэрлэн дүрсэлсэн байна.

А хайтан нь бурхан болсон гүнтний захиалгаар В. А. Моцарт "Реквиём" хэмээх сүнс төвшитгөх алдарт аялгуугаа бичээд, түүндээ уусан шингэж зовлонт ертөнцөөс ангижран, оюуны дээд мандалд урсан одсон тухай зохиогч онгодтой сайхан өгүүлэх ялдамд өөрөө ч бас оюуны дээд мандал өөд авирч яваагаа харуулаад амжжээ. Өөр үгээр хэлбэл уран бүтээл төрөх зовлон жаргалыг биеэр мэдэрсэн хүнд л цутган орж ирэх дүр дүрслэлийг бүтээжээ.

Ү. Хүрэлбаатарыг сэтгүүл зүйд шинэ хүн гэж хэн ч хэлэхгүй байх. Тэрбээр өнөөгийн залуусын өөчлөх дуртай социализмын бүтээгдэхүүн. Гэвч тэр орчин цагийн шинэ сэтгүүл зүйн дэг сургуулийг сүрхий эзэмшсэн нэгэн аж. Шинэ сэтгүүл зүйд зөвхөн мэдээг төдийгүй томоохон нийтлэлийг ч толгойлж бичдэг жаяг тогтсоныг энэ хашир сэтгүүлч хэзээний ажиглаад, ажилдаа хэрэгжүүлээд хэвшүүлчихсэн байна. Жишээ нь "Билгийн мэлмий нээгч" гэдэг төсөрхөн нийтлэл "Гомбожавын Мэнд-Ооёогийн "Билгийн мэлмий нээгч" ном хэвлэгдэн гарав" гэж эхэлсэн байх юм. Яах аргагүй товч лид. Үүнийг хараад мэдээ юм уу гэтэл биш

ажээ. Зохиогч залгаад "Уг номын эхний хуудсанд амгалан бүхнийг эдлүүлэн, таалал нигүүлсэхүйн дээд хутгийг адистэдлэгч, буян хишиг болоод эрдэнэс бүхний хотол чуулган цаглашгүй зөөлөн энэрлээр ертөнц дахиныг болгоон үзэж, билгийн мэлмий нээгч Мигжэд Жанрайсиг шүтээнийг Монгол улсад бүтээн залсан цогт их хөлгөн түүхийг товчоолсон эрдэнийн толь оршвой хэмээн зорилго юугаан тодорхойлжээ" гэж уг номын агуулгыг зохиогчийнх нь хэлсэн үгээр иш татан мэдээлээд авч байна. Хэрэв Хүрэлбаатар энэхүү хоёр дахь өгүүлбэрээр нийтлэлээ эхэлсэн бол нэлээд хуучирсан үгтэй уг өгүүлбэрийг хэн ч уншихгүй өнгөрч болох байв. Гэтэл "ном хэвлэгдэн гарав" гэсэн товч мэдээлэл "Ямар ном бэ?" гэсэн асуултыг өөрийн эрхгүй дагалдуулж байна. Хоёр дахь өгүүлбэр түүнд нь хариулж, цаашид уншигчийг номын агуулгын гүн лүү ягуухан хөтөлжээ. Энэ бол бичсэн зүйлээ яаж бүрэн уншуулах аргыг төгс эзэмшсэн туршлагатай, бас шинэ цагийн дэг сургуультай сэтгүүлчийн хийдэг ажил мөн.

Ү Хүрэлбаатар үгээр урлах эрдэмд мэргэшсэн уран бүтээлч юм. Хэлэх гэсэндээ хүрэхийн тулд тойруулж товшуулж цаг, цаас хоёроо бардаг хүн хааяа тааралддаг. Тийм уран бүтээлчийг сэтгүүл зүйд "Адамаас эхэлдэг" хүн гэж хочилдог. Ү. Хүрэлбаатар тийм сул талаас ангид хүн юм. Тэрээр "Түй түймэр" гэдэг нийтлэлдээ "...Дулаанханы их хөвчт нуруу тэр аяараа уугин шатаж байхыг харахад дайн тулааны гашуун явдал санагдаж, эх орны ногоон хүрэм утаа болон замхарч буйг үзсэн муу заяандаа өөрийн эрхгүй харамсаж явлаа" гэж иргэнлэг сэтгэлийн зовнилоо эвлэгхэн өгүүлсэн байна.

Түүгээр ч зогсохгүй энэ нийтлэлд "Бугантын алтан дэвсгэрт газар шороонд ханхалзан ургасан лүглэгэр их модод", "Зургаадугаар сарын нэгэн" гэдэг нийтлэлд "Зуны тэргүүн сар тэргэл саран авхайгаа илгээж, хүн малын зоо нуруу тэнийсэн цаанаа л нэг нүнжитэй урин цагийн их даллага мэт зургадугаар сард би дуртай", "Оюутны танго" гэдэг уянгын уран нийтлэлд "...зөөлөн цэнхэр аялгуу мөрөөдөл цаламдан хос хунгийн дуу шиг ханьсахын заяаг өгүүлэн", "Од өтгөрч шөнийн амьсгал сэвэлзэн, эдүгээ цагийн оюутны хотхон миний сэтгэлийн ертөнцийг илбэн тохинуулах мэт", "Сүнс тайтгаруулах өргөлийн уншлага" гэдэгт "Тэнгэрийн нигүүлсэл мэт хүнгэнэсэн аялгуу эгшиглэнэ. Гуниглуун атлаа хүндэтгэлтэй, гуншаадуу атлаа цоглог тэр хайлан японы сүнс тайтгаруулах өргөлийн уншлага аж" гэх мэт бараг нийт өгүүлбэрээс нь нуугисан зөөлөн аялгуу сонсогдож, уншихад урам сэргээх аж.

Ү. Хүрэлбаатар уран бүтээлчийн хувьд нийцтэй үгээр унацтай өгүүлж чаддаг шигээ сэтгүүлчийн хувьд нийгмийн амьдралд сиймхий гарахыг анддаггүй соргог нэгэн юм. "Ерөнхий эрхлэгчийн зурвас"-т нэгэн жилийн туршид нийслэл хийгээд нийслэлчүүдийн амьдралд тохиолдсон гэрэлтэй, сүүдэртэй явдлууд бараг төлөв тусгагдсан байна. Тэр бүхэнд эх орныхоо төлөө санаа тавьж явдаг уран бүтээлчийн уярал хайр, ухаарал сэхээрэл, зовиол шаналал цөм багтжээ. Амьдралд шатаж, шаналж явах нь жинхэнэ уран бүтээлчид оногддог тавилан бөгөөд Хүрэлбаатар тэр жишгээс ангид байсангүй. Тэр нь сайн сайхан юмыг хараад баярлаж, урам дэм өгч чаддаг, муу муухай бүхнийг үзээд үзгэн шилбүүрээ авч үгийн сүргээр шүршиж

чаддаг шинжээр нь илрэн гардаг байна. Эрин цагийнхаа агуулгыг мэдэрч, уншигч хэнд ч цаг үеэ үнэлэх луужин болохуйц мэргэн санаа хэлдэг нь их мэдрэмжийн үргэлжлэл аж. Жишээ нь "Оргилуун дарс" гэдэг нийтлэлийг өнгөц харахад шинэ жилийн хөөр баяр, хөнгөн аялгууг дүрсэлсэн мэт боловч, уг чанартаа та бид ямар цаг үед аж төрж байгаа хийгээд, юунд гол анхаарлаа хандуулах ёстойг хэлж өгөхөд чиглэсэн байна. Үүнийгээ "Шинэ технологийн довтолгоон хүчит давалгаан мэт хуйларч, шинэ үзэл санаа сөргөлдөөн, өрсөлдөөн дунд боловсорч хүчирхэгжин, гагцхүү дэлхийн хандлага гэгч нэгэн түвшин бүхнийг залуурдаж байна" гэж тодорхойлоод, ийм замд эргэлтгүй орсон бид одоо л дэлхийн улс болох нь хэмээн улс орныхоо ирээдүйг өөдрөгөөр харсан байх юм.

З охиогч "Би оргилуун дарс амтлан сууна. Савнаасаа гарахдаа догшрохоос бус номхон эд аж. Түүний бөглөө юугаа тийрэн дэлбэрэх их дуун ёслолын буудлагатай ижилсэж, бас ч хувьсгалын тухай бодол төрүүлсэн нь тохиолдол бус аа", гэх буюу "Оргилуун хүслэн, оргилуун эрч хүч, оргилуун залуу нас бүгд нийлээд улс орныхоо тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн төлөө хурайлан босч буй

санагдана" гэхчлэн бичсэн нь тэрхүү өөдрөг үзэлд өргөн түмнээ уриалах санаатай нь холбоотой мэт санагдана. Энэ мэтээр Ү. Хүрэлбаатарын "Ерөнхий эрхлэгчийн зурвас" номонд оночтой унацтай санаа, охтой онгодтой дүрслэл арвин байна. Уг ном Монголын сэтгүүл зүйн туурвилд шинэ содон шигтгээ болж орох нь дамжиггүй.

Ишлэл

- ¹ Наранцацралт Ж. 1998. Зурвасын тухай зурвасхан. "Ерөнхий эрхлэгчийн зурвас". 3 дахь тал.
- ² Хүрэлбаатар Ү. 1998. Ерөнхий эрхлэгчийн зурвас. УБ., 5, 9, 10, 387, 401, 463 дахь талууд.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Хүрэлбаатар Ү. 1998. Ерөнхий эрхлэгчийн зурвас. УБ.
2. Зулкафиль М. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.
3. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл. УБ.
4. Норовсүрэн Л. 2008. Хянан найруулах ухаан. УБ.

Summary

This article analyzed stories included to Mr. Khurelbaatar's book as "Message of Editor in Chief". Analysis concentrates on the more striking features of literary language, skills, writing and wording. The result based on factual analysis on title of the story, content, timely manner, roles and description.